



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.04.24 № A-1/1645  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЗТХЯ/20240101057 дугаартай XV.1.1.81 Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хүчилттай авто замын эхлэл, 92.13 км /Орхон, Дархан-Уул, Төв/ УТ2402804359 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

Тодруулга	Хариулт
<p>Тодруулга авах тухай</p> <p>1.ТШЗ 19.3-т Ажил гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл 5.2.3.1 Авто зам барих / Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай" Зам тээврийн хөгжлийн сайдын 2023 оны A/177 дугаар тушаал /, тусгай зөвшөөрөл нь Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог 2.8.2.1.2 15км хүртэл хатуу хүчилттай авто зам барих тусгай зөвшөөрөлөөр дүйцүүлэн хангаж болох эсэх талаар тодруулж өгнө үү.</p> <p>2.ТШЗ 19.1-т Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хүснэгтийн 3-т "Геодезийн инженер" албан тушаалтан нь Геодезийн инженер мэргэжилтэй байхыг шаардсан байна. ЗТХСайдын 2023 оны 06-р сарын 08 ны A/177 тоот тушаалын Тусгай зөвшөөрөлд тавигдах нэмэлт шаардлагын Мэргэжлийн инженер техникийн ажилтны зэрэг дэвийн тайлбарт: Авто замын мэргэшсэн инженерийг материал, геодезийн инженерээр тооцож болно. Мөн зөвлөх инженерээр тооцож болох талаар тусгасан байна. Иймд "Геодезийн инженер" албан тушаалтang Авто замын мэргэшсэн инженер эсвэл Зөвлөх инженерээр тооцох эсэх талаар тодруулж өгнө үү.</p>	<p>1.Тус төсөл, арга хэмжээний авто замын урт 15 км тул Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог 5.2.3.1 Авто зам барих тусгай зөвшөөрлийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны A/101 дүгээр тушаалаар баталсан 2.8.2.1.2 15 км хүртэл хатуу хүчилттай авто зам барих тусгай зөвшөөрөлтэй дүйцнэ.</p> <p>2.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны A/177 дугаар тушаалаар батлагдсан 5.2.3.1 Авто зам барих тусгай зөвшөөрлийн хүрээнд мэргэжлийн инженер техникийн ажилтны хамгийн бага тоогоор буюу Ерөнхий инженер-1, Авто замын барилгын инженер-1, Гүүр хиймэл байгууламжийн инженер-1, Геодезийн инженер-1, Материалын инженер-1 гэж заасны дагуу тендерийн баримт бичигт холбогдох инженер техникийн ажилтнуудыг тусгасан.</p> <p>Тендерийн баримт бичигт ерөнхий инженер нь авто замын барилгын инженер байх ба мэргэшсэн болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 8 жилээс доoshgүй ажилласан туршлагатай байна гэж заасан. Харин Геодезийн инженер нь Геодезийн инженер мэргэжилтэй байх ба мэргэжлээрээ 5 жилээс доoshgүй жил ажилласан байна гэж заасан.</p> <p>Иймд "Геодезийн инженер" мэргэжлээр тэгссэн ажилтang авто замын мэргэшсэн инженер эсхүл зөвлөх инженерээр тооцох боломжгүй юм.</p>

ДАРГА

Ц.БАТЗУЛ

4020020105 СБТ 11261 6529909

1324024462